



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/081/НА-СТА-ТХН

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn</p> <p>Аудитор: Я.Марал-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn</p> <p>Гэрээгээр гүйцэтгэсэн: “Конфиденсе Аудит” ХХК-ийн захирал: П.Ариунаа Утас: 99994990 Цахим хаяг: ariunaa@confidenceaudit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТЭГШ БОЛОМЖИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗАМААР СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ Б.ЦЭРЭНХАНД ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны эцсээр нийт 5,000.0 мянган ам.долларын тусламжаас 3,783 мянган ам.доллар буюу 12,860,272.7 мянган төгрөгийн санхүүжилт орж, “Тэгш хамран сургах боловсрол” ажлын хүрээнд 2,823,568.8 мянган төгрөг, “Сургуулийн үдийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах” ажлын хүрээнд 505,497.1 мянган төгрөг, “Хосолсон сургалт” ажлын хүрээнд 3,655,899.5 мянган төгрөг, төслийн багийн зардалд 661,984.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж, төслийн гүйцэтгэл 47 хувьтай байна.

“Сургуулийн үдийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах” ажлын хүрээнд зарласан 4,422,336.9 мянган төгрөгийн төсөвтэй худалдан авах ажиллагааны явцад гомдол гарснаас ажил удааширч, төслийн хугацаа хойшлох, төслийн нэгжийн зардал нэмэгдэх нөхцөл үүсээд байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Төсөл сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилготойгоор Улаанбаатар хотын 15, орон нутгийн 30, нийт 45 сургуулийн 6-14 насны 55,224 сурагчийг хамран 2023 оны 9 сарын 1-ээс 2025 оны 9 дүгээр сарын 30 хүртэл 3 жилийн хугацаанд хэрэгжихээр байна.

Үйл ажиллагааны 2024 оны тайлангийн дүгнэлт хэсэгт төслийн хүрээнд нийт 26 ажил төлөвлөснөөс 23 ажлыг бүрэн гүйцэтгэж, 3 ажлыг 2025 онд гүйцэтгэхээр төлөвлөж, тайлант оны гүйцэтгэлийг 91.3 хувь гэж тэмдэглэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	53,572,214.20	5,206,303,082.86
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	50,244,214.39	5,206,303,082.86
3121	Банканд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	19,856,842.37	863,391,633.18
3122	Банканд байгаа бэлэн мөнгө /валютаар/	30,387,372.02	4,342,911,449.68
33	АВЛАГА	27,999.81	42,000.00
3351	Бусад авлага	27,999.81	42,000.00
34	УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	3,300,000.00	-
3460	Урьдчилгаа тооцоо /Байрны барьцаа/	3,300,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	31,083,437.25	5,206,345,082.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	31,083,437.25	23,837,087.43
3920	Машин, тоног төхөөрөмж	24,192,372.00	24,192,372.00
3920	Хуримтлагдсан элэгдэл	(3,756,818.75)	(9,817,914.17)
3920	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,829,900.00	11,829,900.00
3920	Хуримтлагдсан элэгдэл	(1,182,016.00)	(2,367,270.40)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	84,655,651.45	5,230,182,170.29
4	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	43,543,418.00	138,008,558.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	42,938,418.00	122,966,558.00
4136	Бусад өглөг	605,000.00	15,042,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	41,112,233.45	5,092,173,612.29
51	Засгийн газрын хувь оролцоо	41,112,233.45	5,092,173,612.29
512	Хуримтлагдсан үр дүн	41,112,233.45	5,092,173,612.29
5121	Өмнөх үеийн үр дүн	2,050,988,130.33	41,112,233.45
5122	Тайлант үеийн үр дүн	(2,009,875,896.88)	5,051,061,378.84
6	ӨР, ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	84,655,651.45	5,230,182,170.29

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	НИЙТ ОРЛОГЫН ДҮН	74,817,258.20	11,002,003,974.08
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	74,817,258.20	11,002,003,974.08
122	Гадаад зээлийн санхүүжилт	-	10,784,900,085.12
1200	Бараа үйлчилгээний орлого	980,000.00	805,000.00
120044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73,837,258.20	216,298,888.96
2	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	1,360,884,436.77	3,184,183,508.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,360,884,436.77	3,184,183,508.34
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,360,884,436.77	3,184,183,508.34
2101	Цалин	189,613,944.62	194,527,731.01
210101	Үндсэн цалин	189,613,944.62	194,527,731.01
2102	Ажил олгогчоос НДШ	23,699,242.28	24,315,966.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	23,699,242.28	24,315,966.00
2103	Байр ашиглалттай холбоотой	39,583,032.59	48,077,925.15
210301	Гэрэл цахилгаан	-	3,677,925.15
210304	Байрны түрээс	39,583,032.59	44,400,000.00
2104	Хангамж бараа материалын зардал	9,173,915.85	31,435,643.90
210401	Бичиг хэргийн зардал	6,057,647.85	3,462,240.90
210403	Шуудан холбооны зардал	2,475,340.00	2,400,000.00
210406	Жижиг эд хогшил худалдан авах зардал	640,928.00	266,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	570,013.00
210702	Дотоод албан томилолт	-	24,367,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	370,290.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,093,038,121.68	2,878,579,892.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,093,038,121.68	2,878,579,892.46
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,776,179.75	7,246,349.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	837,345.00	-
210903	Элэгдлийн зардал	4,938,834.75	7,246,349.82
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(1,286,067,178.57)	7,817,820,465.74
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	1,394,194.69	27,623,992.54
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /бодит/	1,394,194.69	27,623,992.54
392	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	725,202,913.00	2,794,383,079.44
392050	Тоног төхөөрөмж	725,202,913.00	2,794,383,079.44
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(723,808,718.31)	(2,766,759,086.90)
5	НИЙТ ҮР ДҮН	(2,009,875,896.88)	5,051,061,378.84

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	980,000.00	10,785,705,085.12
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	980,000.00	10,785,705,085.12
122	Гадаад зээлийн санхүүжилт	-	10,784,900,085.12
1200	Туслах үйл ажиллагааны орлого	980,000.00	805,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	1,995,203,610.63	5,657,270,209.19
21	Бараа, үйлчилгээний зардал	1,995,203,610.63	5,657,270,209.19
2101	Цалин	189,641,944.43	194,499,731.20
210101	Үндсэн цалин	189,641,944.43	194,499,731.20
2102	Ажил олгогчоос НДШ	23,699,242.28	24,315,966.00
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	23,699,242.28	24,315,966.00
2103	Байр ашиглалттай холбогдох зардал	42,883,032.59	44,777,925.15
210301	Гэрэл цахилгаан	-	3,677,925.15
210304	Байрны түрээс	39,583,032.59	41,100,000.00
2104	Хангамж бараа материалын зардал	8,539,387.85	31,435,643.90
210401	Бичиг хэргийн зардал	5,650,147.85	3,462,240.90
210403	Шуудан холбооны зардал	2,475,340.00	2,400,000.00
210406	Жижиг эд хогшил худалдан авах зардал	413,900.00	266,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	570,013.00
210702	Дотоод албан томилолт	-	24,367,100.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	370,290.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,040,052,449.48	2,655,171,717.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,040,052,449.48	2,655,171,717.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	690,387,554.00	2,707,069,225.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	690,387,554.00	2,707,069,225.44
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,994,223,610.63)	5,128,434,875.93
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	7,507,000.00	-
392050	Тоног төхөөрөмж	7,507,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨН/ГҮЙЛГЭЭ (VI=(IV)-(V))	(7,507,000.00)	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,394,194.69	27,623,992.54
1452	Валютын ханшийн зөрүү	1,394,194.69	27,623,992.54
8	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	-
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(2,000,336,415.94)	5,156,058,868.47
10	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,050,580,630.33	50,244,214.39
11	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	50,244,214.39	5,206,303,082.86

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	2,050,988,130.33	2,050,988,130.33
2	Тайлант үеийн үр дүн	(2,009,875,896.88)	(2,009,875,896.88)
3	2023 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	41,112,233.45	41,112,233.45
4	Тайлант үеийн үр дүн	5,051,061,378.84	5,051,061,378.84
5	2024 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	5,092,173,612.29	5,092,173,612.29

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,599,017,000.00	5,971,292,238.15	2,627,724,761.85	69.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,599,017,000.00	3,176,909,158.71	422,107,841.29	88.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,599,017,000.00	3,176,909,158.71	422,107,841.29	88.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,800,000.00	194,499,731.20	9,300,268.80	95.4
210101	Үндсэн цалин	203,800,000.00	194,499,731.20	9,300,268.80	95.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,575,000.00	24,315,966.00	1,259,034.00	95.1
210201	Тэтгэврийн даатгал	16,613,000.00	15,354,841.00	1,258,159.00	92.4
210202	Тэтгэмжийн даатгал	2,038,000.00	2,038,000.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,829,000.00	1,828,125.00	875.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,019,000.00	1,019,000.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	4,076,000.00	4,076,000.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,500,000.00	48,077,925.15	2,422,074.85	95.2
210301	Гэрэл, цахилгаан	5,500,000.00	3,677,925.15	1,822,074.85	66.9
210304	Байрны түрээс	45,000,000.00	44,400,000.00	600,000.00	98.7
2104	Хангамж бараа материалын зардал	6,500,000.00	6,128,240.90	371,759.10	94.3
210401	Бичиг хэрэг	3,734,000.00	3,462,240.90	271,759.10	92.7
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,500,000.00	2,400,000.00	100,000.00	96.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	266,000.00	266,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	571,000.00	570,013.00	987.00	99.8
210603	Хөдөлмөр хамгаалал	571,000.00	570,013.00	987.00	99.8
2107	Томилолт зочны зардал	43,471,000.00	24,737,390.00	18,733,610.00	56.9
210702	Дотоод албан томилолт	43,100,000.00	24,367,100.00	18,732,900.00	56.5
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	371,000.00	370,290.00	710.00	99.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,268,600,000.00	2,878,579,892.46	390,020,107.54	88.1
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,268,600,000.00	2,878,579,892.46	390,020,107.54	88.1
22	Хөрөнгийн зардал	5,000,000,000.00	2,794,383,079.44	2,205,616,920.56	55.9
222001	Тоног төхөөрөмж	5,000,000,000.00	2,794,383,079.44	2,205,616,920.56	55.9

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,787,900,085.12	10,787,900,085.12	-	100.0
36	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	10,787,900,085.12	10,787,900,085.12	-	100.0
360001	Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих	10,787,900,085.12	10,787,900,085.12	-	100.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		50,244,214.39		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,206,303,082.86		
	Ханшийн тэгшитгэл	-	27,623,992.54		
	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	4	4	-	100.0
	Удирдах ажилтан	1	1	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	3	3	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл нь Австралийн “Хүүхдийг ивээх сан” болон Монгол Улсын Засгийн газрын хооронд 2022 оны 8 сард байгуулсан гэрээний дагуу 5 сая ам.долларын санхүүжилттэйгээр 3 жилийн хугацаанд хэрэгжинэ.

Төслийн гүйцэтгэгч байгууллага нь Боловсролын яам бөгөөд хэрэгжүүлэх нэгжийг Сангийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 210 дугаар тушаалаар байгуулсан. Тэгш хамруулах хандлагад тулгуурлан боловсролын чанар хүртээмжийг сайжруулах ерөнхий зорилт дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сурч боловсрох орчин, нөхцөлийг сайжруулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах үйлийг дэмжих, чадавхыг нэмэгдүүлэх;
- Сургуулийн аюулгүй, чанартай, тэжээллэг үдийн хоол үйлдвэрлэх орчныг бүрдүүлэх;
- Нийгмийн эмзэг бүлгийн, хангалттай үйлчилгээ авч чаддаггүй болон хоол тэжээлийн тусгай хэрэгцээтэй хүүхдийн хоол тэжээлийн байдлыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;
- Хосолсон сургалтыг хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын тогтолцоог сайжруулах;
- Нөхцөл байдалд тохирсон хосолсон сургалтын загварыг бий болгож, зорилтот сургуулиудад турших.

Төслийн нэгж 3 зорилт, сонгосон хүрээг хамран үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Тэгш хамран сурах боловсрол - Архангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Сүхбаатар аймгууд болон Хан-Уул дүүрэг тус бүрээс 3, нийт 18 сургууль, 300 багш, 130,766 бага, дунд ангийн суралцагч хамрагдах;
- Сургуулийн үдийн хоол - Улаанбаатар хотын 15, орон нутгийн 30, нийт 45 сургуулийн 6-14 насны 55,243 сурагч (50% эмэгтэй, 50% эрэгтэй) хөтөлбөрт хамрагдаж, 36 хоол зүйчийг хөрвүүлэх сургалтаар бэлтгэх;
- Хосолсон сургалт - УБ хотын Чингэлтэй, Хан-Уул дүүрэг, Булган, Дундговь, Сүхбаатар, Ховд, Увс аймгуудын нийт 50 ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтан, суралцагч, эцэг эхчүүдийг хамруулна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус төсөл нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, хувь хүний орлогын албан татварын тухай, Нийгмийн даатгалын тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Шилэн дансны тухай болон бусад холбогдох эрх зүйн актуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Төслийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд тайлант онд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2024 оны Б/60 дугаар тушаал “Цалин шинэчлэн тогтоох тухай”;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод

хяналтын үйл ажиллагааны хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төслийн нэгжийн үйл ажиллагааны хяналтыг Боловсролын яамны гүйцэтгэхээр төсөл хэрэгжүүлэх гарын авлагад заасан бөгөөд үүний дагуу 2024 оны 12 дугаар сард хийгдсэн хяналт, шинжилгээ, үнэлгээний тайланд дурдсанаар төслийн нэгжид 10 зөвлөмж хүргүүлснийг үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна

Санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцсэн, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,145,484.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	53,572.2	5,206,303.1	5,152,772.9
Мөнгөн хөрөнгө	50,244.2	5,206,303.1	5,156,058.9
Авлага	28.0	42.0	14.0
Урьдчилж төлсөн төлбөр	3,300.0	0.0	(3,300.0)
Үндсэн хөрөнгө	31,083.4	23,837.1	(7,246.3)
Нийт хөрөнгийн дүн	84,655.7	5,230,182.2	5,145,526.5
Нийт өр төлбөрийн дүн	43,543.4	138,008.6	94,465.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	41,112.2	5,092,173.6	5,051,061.4
Өр, төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	84,655.7	5,230,182.2	5,145,526.5

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,206,303.1 мянган төгрөг болж өссөн нь тайлант онд төсөвлөсөн худалдан авалтын тендерүүд гомдол гарсны улмаас хойшилсонтой холбоотой,
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 7,246.3 мянган төгрөг болж буурсан нь энэ дүнгээр хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг бүртгэсэн;

- Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 94,465.1 мянган төгрөгөөр өссөн нь 122,966.5 мянган төгрөгөөр 2024 онд худалдаж авсан тоног төхөөрөмжүүдийн баталгаат хугацааны төлбөрийг бүртгэсэн;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 5,051,061.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны ашгийг нэмж бүртгэсэнтэй тус тус холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй" гэж заасан.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн тайлант оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нийт зарлага ба зардлыг 8,599,017.0 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр гадаад зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийн өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс урсгал зардалд 5,971,292.2 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын нийт гүйцэтгэл 69.4 хувьтай байна.

Төслийн нийт зардал 2,627,724.8 мянган төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь хөрөнгө худалдаж авах зардал 2,205,616.9 мянган төгрөг, урсгал зардлыг 422,107.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан, тендерийн шалгаруулалтад маргаан үүсэж худалдан авах үйл ажиллагаа хойшилсонтой холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Урсгал зардал	3,599,017.0	3,176,909.2	422,107.8	88.3
2	Хөрөнгийн зардал	5,000,000.0	2,794,383.1	2,205,616.9	55.9
3	дүн	8,599,017.0	5,971,292.2	2,627,724.8	69.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл хөтөлбөрийн нийт үйл ажиллагааг тусламжийн гэрээнд тусгасан бүрэлдэхүүнээр төсөвтэй харуулбал гүйцэтгэл 47.0 хувьтай байна. Дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 3. Төслийн бүрэлдэхүүн тус бүрээр хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/					
№	Хөтөлбөрийн нэр	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн хувь	Төсөв	Зарцуулсан

1	Бүрэлдэхүүн 1: Тэгш хамран сургах боловсрол	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор ерөнхий боловсролын бага, дунд сургуулиудын чадавхыг нэмэгдүүлэх	76%	3,729,936.0	2,823,568.8
2	Бүрэлдэхүүн 2: Сургуулийн үдийн хоол	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах	10%	5,265,158.4	505,497.1
3	Бүрэлдэхүүн 3: Хосолсон сургалт	Сурагчийн сурлагын амжилтыг сайжруулах зорилгоор хосолсон сургалтын загварыг бий болгоно.	60%	6,068,401.6	3,655,899.5
4	ТХН-ийн зардал		64%	1,039,672.4	661,984.5
5	Хөтөлбөрийн удирдлагын зардал		23%	323,136.0	75,120.6
	Нийт Монголд улсад гарсан зардлын дүн		47%	16,426,304.4	7,722,070.6
6	Хөрөнгө оруулагч талд гарах менежментийн төлбөр		60%	486,995.6	290,136.1
7	Хөрөнгө оруулагч талд гарах төсөл, хөтөлбөрийн зардал		0%	86,700.0	0.0
	Нийт дүн		47%	17,000,000.0	8,012,206.7

Бүрэлдэхүүн тус бүрээр тайлант онд хүрсэн үр дүн дараах байдалтай байна.

Бүрэлдэхүүн 1 Тэгш хамран сургах боловсрол: Ердийн сургуулийн багш, нийт сурагчид, эцэг эхчүүдийг тэгш хамран сургах боловсролын болон шинэчилсэн хөтөлбөрийн сургалтад хамруулах, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, олон улсын туршлага судлах талаар үйл ажиллагаа зохион байгуулсан. Мөн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимд мэргэшсэн багш нарыг томилон ажиллуулах, зөвлөн туслах үйл ажиллагаа явуулсан.

Бүрэлдэхүүн 2 Сургуулийн үдийн хоол: Шим тэжээлийн тусгай хэрэгцээт суралцагчдын хооллолтын байдлыг үнэлэх арга зүйн удирдамжийг боловсруулж, хэрэгжүүлэх, хоол зүйч, тогооч нарт зориулсан сургалтын материалыг боловсруулах, сургалт зохион байгуулж, сурагчдын нэмэлт хоол болон хичээлээс гадуурх хүүхэд төвтэй хоол тэжээл, эрүүл мэндийн хөтөлбөрийг туршин хэрэгжүүлж байна. Мөн хөрвүүлэх сургалтад хамрагдаж байгаа оюутнуудын сургалтын төлбөрт санхүүжилт олгосон.

Бүрэлдэхүүн 3: Хосолсон сургалт: Хосолсон сургалтын чиглэлээр жишиг, стандартуудыг бий болгож, бага, дунд боловсролын сургуулиудад хосолсон сургалтыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлж мөн хосолсон сургалтын тогтолцоог бага, дунд боловсролын сургуулиудад хэрэгжүүлэх боловсон хүчнийг үндэсний болон орон нутгийн түвшинд чадавхжуулан ажилласан байна. Энэ ажлын хүрээнд сургуулиудын мэдээлэл технологийн ажилчид, багш сурган хүмүүжүүлэгч нар мөн эцэг эхчүүдийг сурган ажилласан. Мөн сургуулиудын WIFI холболт, программ хангамж, зорилтот сургуулиудад дижитал тоног төхөөрөмжийн багцаар хангасан.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Тэгш боломжийг бүрдүүлэх замаар боловсролыг дэмжих төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төслийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр, урьдчилж гарсан зардал үүсгэхгүй байх, үр ашиггүй зардал гаргахгүй талаар зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Конфиденсе Аудит ХХК-ийн Ахлах аудитор Э.Энхтуул гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг Г.Шинэцэцэг, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүү, нийцлийн аудитын газрын аудитор Я.Марал-Эрдэнэ, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар боловсролыг дэмжих төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 09 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 5,760,189.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 57,601.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон, хязгаарласан арга хэмжээг тайлант онд санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн Шилэн дансны тухай хууль, тогтоомжтой холбоотой зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 3 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст худалдан авах ажиллагааны тайланг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, шилэн дансны цахим хуудсанд мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд нь, бүрэн мэдээлж, хуулийг мөрдөн ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн 2,821,220 мянган төгрөгийн зөрчилд хүргүүлсэн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хэрэгжиж гүйцэтгэл 100.0 хувь байна.

Хүснэгт 4. Зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	2,821,220	1	2,821,220	100
Нийт дүн	1	2,821,220	1	2,821,220	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсөл 2025 онд дуусгавар болох тул Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журамд заасан төсөл дуусгавар холбоотой заалтуудыг баримтлан ажилласан эсэхийг шалгах. Үүнд тусгай данснуудыг хаах, ажилчдын хөдөлмөрийг гэрээг дуусгавар болгох, санхүү тайланг ирүүлэх, хөрөнгө шилжүүлэх гэх мэт заалтуудыг биелэлтийг шалгана.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 15,042.0 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

Залруулсан алдаа:

- Цалингаас суутгах ХХОАТ-ыг буруу тооцоолж, ажилтнаас 42.0 мянган татвар илүү суутгасан;
- Тайлант оны аудитын төлбөр 15,000.0 мянган төгрөгийн өглөг, зардлыг орхигдуулсан;

Санхүүгийн тайлангийн аудитаар материаллаг зөрчил илрээгүй тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 15,042.0 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Цалингаас суутгах ХХОАТ-ыг буруу тооцоолж, ажилтнаас 42.0 мянган татвар илүү суутгасан	1	42.0	1	42.0	-	-	1	42.0	-	-	-	-
2	2024 оны аудитын төлбөрийг аккрузл суурийн дагуу зардалд бүртгээгүй байна.	1	15,000.0	1	15,000.0	-	-	1	15,000.0	-	-	-	-
	Дүн	2	15,042.0	2	15,042.0	-	-	2	15,042.0	-	-	-	-

Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 2,988,764.3 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Шилэн дансны цахим хуудаст худалдан авах ажиллагааны тайланг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	2,988,764.3	-	-	1	2,988,764.3
	Дүн	1	2,988,764.3	-	-	1	2,988,764.3